**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 23 № 01/149 ДУА-2018/83/СТА-ПШЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад төсвийн хэмнэлтийн горимд шилжсэн тогтоолыг зөрчин байгууллагын ажилчдын дунд **581,300.00** /Таван зуун наян нэгэн мянга гурван зуун/ төгрөгөөр тэмцээн, уралдаан зохион байгуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Монгол Улсын Засгийн газрын 147-р тогтоолын 3.6-д /улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т */Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т */Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д */Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/* заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, хэмнэлтийн горимд шилжин ажиллах,
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч Б.Амгаланжаргал, нягтлан бодогч Б.Сайхантуяа нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН**[1]: **ЗӨВШӨӨРСӨН:**

АУДИТОР Т.ОЮУН-ЭРДЭНЭ ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ Б.САЙХАНТУЯА

1 *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*